

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2009 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ  
батлах тухай

"Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 8 дугаар  
зүйлийн 8.3 дахь, "Ойн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн  
12.1.13 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Ойн сангийн нэг шоометр модны экологи-эдийн засгийн  
үнэлгээг 1 дүгээр, Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн нэг га талбайн  
экологи-эдийн засгийн үнэлгээг 2 дугаар, Ойн сангийн ойгоор  
бүрхэгдээгүй нэг га талбайн экологи-эдийн засгийн үнэлгээг  
3 дугаар, Нэг ширхэг зулзаган, залуу модны экологи-эдийн  
засгийн үнэлгээг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус шинэчлэн  
баталсугай.

Хоёр. Аймаг, нийслэл, сум, дүүрэг болон ойн сангийн  
тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж,  
байгууллагын ойн сан болон улсын ойн нөөцийг мөнгөн дүнгээр  
илэрхийлэх, түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хүний зүй бус үйл  
ажиллагаанаас ойн санд учирсан төрөл бүрийн хохирол, түүний  
ажан төлбөрийн хэмжээг тогтоох, ойн нөөцийн түрээсийн хэмжээг  
тодорхойлох, ойн санг өөр зориулалтаар ашиглуулахаар бусдад  
илгоход өртөг, үр ашгийг тооцох зэрэгт ойн экологи-эдийн  
засгийн үнэлгээг мөрдүүлж ажиллахыг Ойн газар /М.Тунгалаг/,  
аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга  
дэргэд тус тус даалгасугай.

Гурав. Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ шинэчлэн  
батлагдсантай холбогдуулан "Ойн нөөцийн экологи-эдийн засгийн  
үнэлгээг батлах тухай" Байгаль орчны сайдын /хуучин нэрээр/  
2002 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 93 дугаар тушаал,  
"Хуш модны экологи-эдийн засгийн үнэлгээг батлах тухай"  
Байгаль орчны сайдын 2003 оны 10 дугаар сарын 07-ний өдрийн  
184 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Л.ГАНСУХ

А.Сайнбаяр

081070



Байгаль орчин, аялал жуулчлалын  
сайдны 2009 оны 12 сарын 11-ний өдрийн  
...394... дугаар тушаалын дүгээр хавсралт



ОЙН САНГИЙН НЭГ ШООМЕТР МОДНЫ  
ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

/Төгрөг/

Д/д	Модны төрөл	Ойн нөөцийн төлбөрийн			
		Нэгдүгээр муж	Хоёрдугаар муж	Гуравдугаар муж	Дөрөвдүгээр муж
1	Жодоо	408000	268000	192000	108000
2	Хуш	336600	217800	158400	89100
3	Гацуур	306000	201000	144000	81000
4	Нарс	255000	165000	120000	66000
5	Шинэс	204000	132000	96000	54000
6	Хайлаас	141000	93000	66000	36000
7	Хус	120000	78000	57000	30000
8	Улиас, улиангар	102000	66000	48000	27000
9	Бургас	90000	60000	42000	24000
10	Заг	90000	60000	42000	24000
11	Бусад /тоорой, жигд, сухай/	81000	51000	36000	21000
12	Бүх төрлийн хэрэглээний хуурай мод	60000	39000	28500	15960

**Тайлбар:** Нэг шоометр модны экологи-эдийн засгийн үнэлгээг мод, модон материалд шилжүүлэхэд бэлтгэсэн мод, модон материалын ашиглалтын гарцын дагуу дараах итгэлцүүрээр үржүүлнэ. Үүнд:

1. Зүсмэл материал, дүнз - 2.9
2. Хэрэглээний бөөрөнхий мод, гуалин - 1.8
3. Туушийн мод - 1.4
4. Түлээ /хуурай/ - 1.0
5. Түлээ /нойтон/ - 1.4

Байгаль орчин, аялал жуулчлалын  
сайдны 2009 оны 12 сарын 11-ний өдрийн  
... 394. дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ОЙН САНГИЙН ОЙГООР БҮРХЭГДСЭН НЭГ ГА ТАЛБАЙН  
ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

/мян.төг/

Д/д	Зонхилох модны төрөл	Ойн нөөцийн төлбөрийн			
		Нэгдүгээр муж	Хоёрдугаар муж	Гурав - дугаар муж	Дөрөв-дүгээр муж
1	Жодоо	49200.0	32400.0	23200.0	13200.0
2	Хуш	42075.0	27720.0	19800.0	11385.0
3	Гацуур	36900.0	24300.0	17400.0	9900.0
4	Нарс	38100.0	24900.0	18000.0	10200.0
5	Шинэс	25500.0	16800.0	12000.0	6900.0
6	Сөөг, торлог	14286.0	9286.0	6857.0	3943.0
7	Хус	11100.0	7200.0	5100.0	2940.0
8	Хайлаас	9900.0	6600.0	4800.0	2670.0
9	Улиас, улиангар	8400.0	5400.0	3900.0	2220.0
10	Бүх төрлийн хэрэглээний хуурай мод	7400.0	4800.0	3400.0	1955.0
11	Бургас	5400.0	3600.0	2610.0	1470.0
12	Заг	3210.0	2100.0	1530.0	840.0
13	Бусад /тоорой, жигд, сухай/	1620.0	1050.0	780.0	420.0

**Тайлбар:** Ойгоор бүрхэгдсэн талбайд байгалийн ой, таримал ой, сөөг, торлог орно.



Байгаль орчин, аялал жуулчлалын  
 сайдын 2009 оны 12 сарын 11-ний өдрийн  
 ...399... дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ОЙН САНГИЙН ОЙГООР БҮРХЭГДЭЭГҮЙ НЭГ ГА ТАЛБAYН  
 ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

/ мян.төг/

д/д	Талбайн төрөл	Ойн шөцийн төлбөрийн			
		Нэгдүгээр муж	Хоёрдугаар муж	Гуравдугаар муж	Дөрөвдүгээр муж
1	Тармаг ой	10200.0	6720.0	4800.0	2760.0
2	Ойн хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн талбай	8500.0	5600.0	4000.0	2300.0
3	Түймэрт шатсан талбай	7650.0	5040.0	3600.0	2070.0
4	Ойжуулсан талбай / улсын ойн санд хүлээж аваагүй талбай/	7300,0	4980.0	3700.0	2340.0
5	Мод бэлтгэсэн талбай	6800.0	4480.0	3200.0	1840,0

Байгаль орчин, аялал жуулчлалын  
 сайдын 2009 оны 12 сарын 11-ний өдрийн  
 ... 394 ... дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



НЭГ ШИРХЭГ ЗУЛЗГАН, ЗАЛУУ МОДНЫ  
 ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

/мян.төг/

д/д	Модны төрөл	Модны өндрийн хэмжээ /метр/						
		<1	1-2	2-3	3-4	4-5	5-6	6<
1	Шилмүүст мод	50,0	100,0	150,0	200,0	250,0	300,0	350,0
2	Навчит мод	30,0	60,0	90,0	120,0	150,0	200,0	250,0
3	Сөөг	5,0						

**Тайлбар:**

1. Ойгоос мод авч, айл өрх, албан байгууллагын тохижилт, цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэн суулгах зориулалтаар зөвшөөрөлгүй ашигласан тохиолдолд энэхүү үнэлгээг ашиглана.

2. Шилмүүст модонд: шинэс, нарс, хуш, гацуур, жодоо; навчит модонд: хус, хайлаас, улиас, улиангар, бургасыг хамруулна.

-----оо-----